НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 дугаар сарын 09 Дугаар 54 Улаанбаатар хот

Түр хамгаалах байр байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалт, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын наймдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах зорилгоор Баянзүрх дүүргийн түр хамгаалах байрыг байгуулж, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн харьяанд ажиллуулсугай.

2.Түр хамгаалах байрны хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай төсвийг шийдвэрлэж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Баярмөнх)-д үүрэг болгосугай.

3.Түр хамгаалан байрлуулах үйлчилгээг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байршуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу үзүүлэхийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс (Ц.Үүрцайх)-т үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА А.БАЯР